ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5		
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5		
Хэсгийн оноо				**4**	**3**	
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	
Хэсгийн оноо				**3**	**3**	
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүнд хөдөлгөөний бүртгэсэн байдал		1	1	
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал		1	1	
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	1	
Хэсгийн оноо				**3**	**3**	
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9**	

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос харьяа агентлаг, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон бусад эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд чиглэл өгч, мэргэжил арга зүй, мэдээллээр ханган ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийг нийт албан хаагчдын санал асуулгаар олонхын дэмжлэг авсан хүнийг сонгож, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/56 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. 2025 онд Ёс зүйн дэд хорооны дарга болон гишүүдээр ажиллаж байсан албан хаагчид өөр ажилд шилжих, өндөр насны тэтгэвэрт гарсантай холбогдуулан яамны албан хаагчдаас 2 удаагийн санал асуулгаар гишүүдээ нөхөн сонгож томилсон. Ёс зүйн дэд хорооны 1 гишүүн 2025 оны 12 дугаар сараас өөр ажилд шилжиж, одоогоор 6 гишүүнтэй ажиллаж байна.

2025 оны байдлаар Эрүүл мэндийн яамны харьяа 14 байгууллага Ёс зүйн дэд хороог 7 гишүүний бүрэлдэхүүнтэй тус тус байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (2025.07.03-ны А/94 дүгээр тушаал);
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (2025.06.05-ны А/127 дугаар тушаал);
- Эрүүл мэндийн хөгжлийн төв (2024.07.16-ны А/82 дугаар тушаал);
- Улсын нэгдүгээр төв эмнэлэг (2025.03.27-ны А/95 дугаар тушаал);
- Улсын гуравдугаар төв эмнэлэг (2024.09.25-ны А/222 дугаар тушаал);
- Гэмтэл согог судлалын үндэсний төв (2025.08.20-ны А/123 дугаар тушаал);
- Арьсны өвчин судлалын үндэсний төв (2024.10.28-ны А/43 дугаар тушаал);
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (2025.10.30-ны А/155 дугаар тушаал);
- Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II (2025.09.12-ны А/39 дүгээр тушаал);
- Хавдар судлалын үндэсний төв (2025.09.10-ны А/60 дугаар тушаал);
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (2025.09.18-ны А/275 дугаар тушаал);
- Хүүхдийн төв сувилал (2025.06.27-ны А/35 дугаар тушаал);
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (2025.03.31-ний А/23 дугаар тушаал);
- Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (2025.11.27-ны Б/454 дүгээр тушаал) зэрэг болно.

Эрүүл мэндийн яамны харьяа 24 байгууллагаас 14 буюу 87.5 хувь нь Ёс зүйн дэд хороог байгуулсан байна. Эдгээр эрүүл мэндийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 11 нь буюу 78.6 хувь нь 2025 онд байгуулжээ.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын дагуу төрийн 10 байгууллагыг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосонд Эрүүл мэндийн яам орсон. Аргачлалын дагуу яамны албан хаагч тус бүрт удирдах, гүйцэтгэх албан тушаалын дагуу код олгож, үнэлгээний хуудсыг албан хаагчдад илгээж, үнэлгээнд цахимаар хамруулах ажлыг зохион байгуулсан. Эрсдэлийн үнэлгээнд ЭМЯ-ны 53 албан хаагч хамрагдсан. Үнэлгээний аргачлалын дагуу гарсан үр дүнг нэгтгэж, Ёс зүйн хороонд хүргүүлсэн. Ёс зүйн хорооноос “Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчил: Иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа” болон “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ”-ний үр дүнг танилцуулах, хэлэлцэх цахим уулзалтыг 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүд цахимаар идэвхтэй оролцсон.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсниий хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 оны 10 дугаар сард “Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчил: Иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа”-г цахимаар авсан. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо энэхүү судалгаанд яамны албан хаагч болон үйлчилгээ авч буй иргэдийг идэвхтэй оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулж, судалгаанд яамны 76 албан хаагч, 32 иргэн оролцож, судалгааг бөглөсөн байна.

2025 онд Эрүүл мэндийн яамны албан хаагчдад ёс зүйн чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Тухайлбал,

- Удирдлагын академитай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр "Ёс зүйн тулгамдсан асуудал" сэдэвт сургалтыг яамны нийт албан хаагчдад зохион байгуулж, 71 албан хаагч оролцсон;
- Байгууллагын албан хаагчдад үнэт зүйлд суурилсан ёс зүйн манлайллыг бий болгох, байгууллагын соёлыг зөв төлөвшүүлэх, хувь хүний ёс зүйн зан үйлийг нэмэгдүүлэх чадвар олгох зорилгоор Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Төрийн захиргааны удирдлагын газартай хамтран 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр “Үнэт зүйлд суурилсан манлайлал: Байгууллагын соёл ба хувь хүний зан үйл” сэдэвт сургалтыг зохион байгуулж, яамны 63 албан хаагч оролцсон.

Эрүүл мэндийн яамнаас байгууллагын соёлыг төлөвшүүлэн түгээн дэлгэрүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын ёс зүйн манлайллыг хөгжүүлэх замаар харилцан хүндэтгэлтэй, тэгш оролцоог хангасан ажлын эерэг орчин болгон бүрдүүлэх зорилгоор “Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд бидний оролцоо” сэдэвт нөлөөллийн аян зохион байгуулах удирдамжийг Дэд хорооны даргаар 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдөр батлуулж, харьяа эрүүл мэндийн байгууллагууд 2025.06.16-07.05-ны өдрүүдэд 14 хоногийн нөлөөллийн аян зохион байгуулсан. Аяны тайланг Улсын гуравдугаар төв эмнэлэг, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Эмгэг судлалын үндэсний төв, Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв зэрэг 6 байгууллага тус тус ирүүлсэн. Аяны хүрээнд сургалт, хэлэлцүүлэг, АХА тэмцээн, уралдаан, нээлттэй хаалганы өдөрлөг зэргийг зохион

байгуулж, идэвх, санаачлагатай ажилласан Тухайлбал, дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Улсын гуравдугаар төв эмнэлгийн төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын хэмжээнд мөрдөгддөг эрх зүйн актуудыг сурталчлан таниулах, нийт эмч, ажилчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх "Бид ёс зүйтэй хамт олон" сэдвийн хүрээнд АХА тэмцээн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан.

2. Улсын гуравдугаар төв эмнэлэг: Харилцаа хандлагаараа манлайлсан ажилтныг олон нийтэд таниулах зорилтын хүрээнд “Би эхлэвэл бид өөрчлөгдөнө” аяны хүрээнд “Видео шторк" уралдаан зохион байгуулж, тэргүүн байр 3үрх судасны үндэсний төвийн харьяа тасгууд (250,000 төгрөг), дэд байр БДДШТ, УСТ, ХБЭСТ-ийн нэгдсэн баг (150,000 төгрөг), гутгаар байр МУЭТ, ММЗНТ, ЕЭТ, СЗТөвийн нэгдсэн баг (100,000 төгрөг) тус тус шалгарч, урамшуулал олгосон.

3. Талархалын аянг нийт 22 тасаг, нэгжийн эмч, сувилагч, мэргэжилтний дунд зохион байгуулж, 115 хүнд ил захидал, 102 хүнд мессежээр талархал илэрхийлсэн байна (Улсын гуравдугаар төв эмнэлэг, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II).

4. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэнтэй хамтран албан хаагчдад “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн тулгуур зарчим”, “Ёс зүй харилцаа хандлага”, “Эрүүл мэндийн ажилтны хууль эрх зүйн асуудлууд”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг Эмгэг судлалын үндэсний төв, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II зохион байгуулж, 502 (давхардсан тоогоор) ажилтан хамрагдсан.

5. “Сар бүрийн 3-Цусаа бэлэглэх өдөр”-ийг HWPL олон улсын байгууллагын Монгол дахь салбартай хамтран зохион байгуулан нийт хамт олны дунд “Ёс зүй-Байгууллагын соёл” сэдвээр сургалт зохион байгуулсан (Цус сэлбэлт судлалын үндэсний төв);

Шинээр ажилд орсон ажилтнуудад Эмгэг судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв сургалт зохион байгуулсан.

6. “Хамтдаа хэлэлцье” уулзалт: Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдын санал, бодлыг чөлөөтэй солилцох, санал авах нээлттэй хэлэлцүүлэг 2025.06.25-ны өдөр “Өглөөний цайтай уулзалт” сэдвийн дор зохион байгуулж, нийт 14 тасагт “Ёс зүйн хавтас” бэлдэн тараан өгсөн. Хэлэлцүүлэгт нийт 108 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилтан хамрагдсан (Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II).

7. Байгууллагын ёс зүйтэй, зөв харилцаа хандлагатай нэг албан тушаалтныг жил бүр “Шилдэг ёс зүйтэй” ажилтнаар шалгаруулахаар (Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв) байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжүүлж байна.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйтэй, ил тод, шударга хандлагаар албан хаагчдад үлгэрлэн манлайлан ажиллаж байна. “Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Ерөнхий сайдын 2025 оны 64 дүгээр захирамжийг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/331 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:	
Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, Ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, тайлан мэдээ гаргах үндсэн чиг үүргийн хүрээнд нийт 15 үйл ажиллагааг олонхын саналаар батлсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 91.0 хувийн хэрэгжилттэй байна. Эрүүл мэндийн яамны Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдэж байгаатай холбогдуулан ёс зүйн зөрчлийн хэлбэрүүдийг дурдаж оруулах, ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд хийгдэх зохицуулалт, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх тухай бүлэг нэмэлтээр оруулах санаачилга гаргаж, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх тухай бүлэг, ажилтан хоорондын харилцаа (ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамт)-ны хүрээнд 2025 оны 04 дүгээр сард санал өгч ажилласан. Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд https://moh.gov.mn/p/180 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байршуулж, тухай бүр шинэчилж байна. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 онд нийт 10 удаа хуралдаж, 19 асуудал хэлэлцсэн байна. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 2025 онд нийт 21 өргөдөл, гомдол, хүсэлт ирснээс хугацаанд нь шийдвэрлэсэн 20, хугацаа хоцорсон, шийдвэрлээгүй байгаа 1 тус тус байна. Өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлт 2025 оны байдлаар 95.2 хувьтай байна. 4 албан хаагчид ёс зүйн зөрчил гаргаагүй талаар тодорхойлолтыг гаргаж өгсөн. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/66 дугаар тушаалаар Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх урамшуулал улиралд нэг удаа, нарийн бичгийн даргад сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50%-тай тэнцэх урамшуулал олгохоор шийдвэрлэн олгож байна. 2025 оны эхний 11 сарын байдлаар нийт 16.5 сая төгрөгийн урамшууллыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгосон байна. 2025 оны IV улирлын урамшуулал олгоогүй байна. Мөн Ёс зүйн дэд хороодын гишүүд, яамны төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулахад байгууллагаас 1,080,000 төгрөг зарцуулж, дэмжлэг үзүүлсэн.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
1. Эрүүл мэндийн яамны харьяа 24 байгууллагаас 14 буюу 87.5 хувь нь Ёс зүйн дэд хороог байгуулсан байна. 2. Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургагч багш бэлтгэх” сургалтад Эрүүл мэндийн яам, харьяа байгуулагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 4 гишүүн хамрагдаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох дүрэм, журамтай нарийвчлан танилцаж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар кейс дадлага ажиллаж, тодорхой мэдлэгтэй болж байна. 3. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын гишүүдэд хуулийн дагуу	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдахаас өмнө Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1 дүгээр заалтад Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дэргэд ёс зүйн салбар хороо тус тус ажиллана гэж заасан. Үүний дагуу Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, эрүүл мэндийн байгууллагуудад ёс зүйн хяналтын салбар хороо, хэсгийн хороо байгуулагдан ажиллаж байна.

урамшуулал олгож байгаа нь гишүүдийг идэвх, санаачлагатай ажиллах хөшүүрэг болж байна.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд батлагдсанаас хойш эрүүл мэндийн байгууллагуудад 2024 оноос Ёс зүйн дэд хороо байгуулагдаж эхэлсэн. Одоогоор Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо (15 хүний бүрэлдэхүүнтэй) болон Ёс зүйн дэд хороо (7 хүний бүрэлдэхүүнтэй) тус тус ажиллаж байна. Мөн эрүүл мэндийн байгууллагуудад Ёс зүйн дэд хороо болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын салбар хороо, хэсгийн хороо зэрэг ажиллаж байгаа нь давхардал үүсгэж байна. Иймээс эрүүл мэндийн байгууллагуудад Ёс зүйн дэд хороо байгуулагдахгүй, удаашрах хандлага ажиглагдаж байна. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, салбар хороо, хэсгийн хорооны гишүүд ямар нэгэн урамшуулал авдаггүй.
Санал:	
Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа Ёс зүйн дэд хороо болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хорооны давхардлыг арилгах талаар судлах зайлшгүй шаардлага тулгарч байгаад анхаарч өгнө үү.	

Шалгах хэсэг:

☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Төрийн нарийн бичгийн дарга _____ Д.Очирбат

Ёс зүйн дэд хорооны дарга

Бодлого төлөвлөлтийн газрын
ахлах шинжээч _____ С.Жаргалсайхан

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын ахлах шинжээч _____ С.Энхжин

Огноо: ..... оны ..... сарын .....

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийг нийт албан хаагчдын санал асуулгаар олонхын дэмжлэг авсан хүнийг сонгож, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/56 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан.

2025 онд Ёс зүйн дэд хорооны дарга болон гишүүдээр ажиллаж байсан албан хаагчид өөр ажилд шилжих, өндөр насны тэтгэвэрт гарсантай холбогдуулан яамны албан хаагчдаас 2 удаагийн санал асуулгаар гишүүдээ нөхөн сонгож томилсон. Ёс зүйн дэд хорооны 1 гишүүн 2025 оны 12 дугаар сараас өөр ажилд шилжиж, одоогоор 6 гишүүнтэй ажиллаж байна.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, Ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, тайлан мэдээ гаргах үндсэн чиг үүргийн хүрээнд нийт 15 үйл ажиллагааг олонхын саналаар батлсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 91.0 хувийн хэрэгжилттэй байна.

Эрүүл мэндийн яамны Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдэж байгаатай холбогдуулан ёс зүйн зөрчлийн хэлбэрүүдийг дурдаж оруулах, ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд хийгдэх зохицуулалт, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх тухай бүлэг нэмэлтээр оруулах санаачилга гаргаж, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх тухай бүлэг, ажилтан хоорондын харилцаа (ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамт)-ны хүрээнд 2025 оны 04 дүгээр сард санал өгч ажилласан.

Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд https://moh.gov.mn/p/180 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байршуулж, тухай бүр шинэчилж байна.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос харьяа агентлаг, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон бусад эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд чиглэл өгч, мэргэжил арга зүй, мэдээллээр ханган ажиллаж байна. 2025 оны 12 дугаар сарын байдлаар Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Хавдар судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн төв сувилал,

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв зэрэг 14 байгууллага Ёс зүйн дэд хороо байгуулан ажиллаж байна.

Хоёр. Зохион байгуулсан Ёс зүйн дэд хорооны хуралдаан, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах талаар

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 онд нийт 10 удаа хуралдаж, 19 асуудал хэлэлцсэн байна.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 2025 онд нийт 21 өргөдөл, гомдол, хүсэлт ирснээс хугацаанд нь шийдвэрлэсэн 20, хугацаа хоцорсон, шийдвэрлээгүй байгаа 1 тус тус байна. Өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлт 2025 оны байдлаар 95.2 хувьтай байна.

4 албан хаагчид ёс зүйн зөрчил гаргаагүй талаар тодорхойлолтыг гаргаж өгсөн.

Гурав. Албан хаагчдыг ёс зүйн чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах

2025 онд Эрүүл мэндийн яамны албан хаагчдад ёс зүйн чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Тухайлбал,

- Удирдлагын академитай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр "Ёс зүйн тулгамдсан асуудал" сэдэвт сургалтыг яамны нийт албан хаагчдад зохион байгуулж, 71 албан хаагч оролцсон;
- Байгууллагын албан хаагчдад үнэт зүйлд суурилсан ёс зүйн манлайллыг бий болгох, байгууллагын соёлыг зөв төлөвшүүлэх, хувь хүний ёс зүйн зан үйлийг нэмэгдүүлэх чадвар олгох зорилгоор Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Төрийн захиргааны удирдлагын газартай хамтран 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр “Үнэт зүйлд суурилсан манлайлал: Байгууллагын соёл ба хувь хүний зан үйл” сэдэвт сургалтыг зохион байгуулж, яамны 63 албан хаагч оролцсон.





Байгууллагын соёлыг төлөвшүүлэн түгээн дэлгэрүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын ёс зүйн манлайллыг хөгжүүлэх замаар харилцан хүндэтгэлтэй, тэгш оролцоог хангасан ажлын эерэг орчин болгон бүрдүүлэх зорилгоор “Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд бидний оролцоо” сэдэвт нөлөөллийн аян зохион байгуулах удирдамжийг Дэд хорооны даргаар 2025 оны 06

дугаар сарын 11-ний өдөр батлуулж, харьяа эрүүл мэндийн байгууллагууд 2025.06.16-07.05-ны өдрүүдэд 14 хоногийн нөлөөллийн аян зохион байгуулсан. Аяны тайланг Улсын гуравдугаар төв эмнэлэг, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Эмгэг судлалын үндэсний төв, Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв зэрэг 6 байгууллага тус тус ирүүлсэн. Аяны хүрээнд сургалт, хэлэлцүүлэг, АХА тэмцээн, уралдаан, нээлттэй хаалганы өдөрлөг зэргийг зохион байгуулж, идэвх, санаачлагатай ажилласан Тухайлбал, дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Улсын гуравдугаар төв эмнэлгийн төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын хэмжээнд мөрдөгддөг эрх зүйн актуудыг сурталчлан таниулах, нийт эмч, ажилчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх "Бид ёс зүйтэй хамт олон" сэдвийн хүрээнд АХА тэмцээн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан.

2. Улсын гуравдугаар төв эмнэлэг: Харилцаа хандлагаараа манлайлсан ажилтныг олон нийтэд таниулах зорилтын хүрээнд “Би эхлэвэл бид өөрчлөгдөнө” аяны хүрээнд “Видео шторк" уралдаан зохион байгуулж, тэргүүн байр Зүрх судасны үндэсний төвийн харьяа тасгууд (250,000 төгрөг), дэд байр БДДШТ, УСТ, ХБЭСТ-ийн нэгдсэн баг (150,000 төгрөг), гутгаар байр МУЭТ, ММЗНТ, ЕЭТ, СЗТөвийн нэгдсэн баг (100,000 төгрөг) тус тус шалгарч, урамшуулал олгосон.

3. Талархалын аянг нийт 22 тасаг, нэгжийн эмч, сувилагч, мэргэжилтний дунд зохион байгуулж, 115 хүнд ил захидал, 102 хүнд мессежээр талархал илэрхийлсэн байна (Улсын гуравдугаар төв эмнэлэг, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II).

4. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэнтэй хамтран албан хаагчдад “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн тулгуур зарчим”, “Ёс зүй харилцаа хандлага”, “Эрүүл мэндийн ажилтны хууль эрх зүйн асуудлууд”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг Эмгэг судлалын үндэсний төв, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II зохион байгуулж, 502 (давхардсан тоогоор) ажилтан хамрагдсан.

5. Шинээр ажилд орсон ажилтнуудад Эмгэг судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв сургалт зохион байгуулсан.

6. “Хамтдаа хэлэлцье” уулзалт: Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажиллагсдын санал, бодлыг чөлөөтэй солилцох, санал авах нээлттэй хэлэлцүүлэг 2025.06.25-ны өдөр “Өглөөний цайтай уулзалт” сэдвийн дор зохион байгуулж, нийт 14 тасагт “Ёс зүйн хавтас” бэлдэн тараан өгсөн. Хэлэлцүүлэгт нийт 108 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилтан хамрагдсан (Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II).

7. Байгууллагын ёс зүйтэй, зөв харилцаа хандлагатай нэг албан тушаалтныг жил бүр “Шилдэг ёс зүйтэй” ажилтнаар шалгаруулахаар (Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв) байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагууд нь албан хаагчдыг ёс зүйн чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулахдаа тайлагналтыг тоо, баримттай, хамрагдсан


ажилтны тоо, гарсан үр дүн зэргийг тодорхой тайлагнаж байхад анхаарах шаардлагатай байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсниий хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 оны 10 дугаар сард “Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчил: Иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа”-г цахимаар авсан. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо энэхүү судалгаанд яамны албан хаагч болон үйлчилгээ авч буй иргэдийг идэвхтэй оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулж, судалгаанд яамны 76 албан хаагч, 32 иргэн оролцож, судалгааг бөглөсөн байна.

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал” батлагдсан. Төрийн 10 байгууллагыг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосонд Эрүүл мэндийн яам орсон.

Хүний эрхийн Үндэсний комисс	92
Санхүүгийн зохицуулах хороо	81
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	71
Эрүүл мэндийн яам	62
СХД-ийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Ажлын алба	23
Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар	35
Төрийн худалдан авах ажиллагааны газар	53
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	91
Багануур дүүргийн Шүүхийн тамгын газар	40
Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	27

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ нь зөвлөн туслах, соён гэгээрүүлэх, эрсдэлийг бууруулахтай холбоотой арга хэмжээг төлөвлөхөд чиглэгдэж байгаа юм. ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын дагуу яамны албан хаагч тус бүрт удирдах, гүйцэтгэх албан тушаалын дагуу код олгож, үнэлгээний хуудсыг албан хаагчдад илгээж, үнэлгээнд цахимаар хамруулах ажлыг зохион байгуулсан. Эрсдэлийн үнэлгээнд ЭМЯ-ны 53 албан хаагч хамрагдсан. Үнэлгээний аргачлалын дагуу гарсан үр дүнг нэгтгэж, Ёс зүйн хороонд хүргүүлсэн.



Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний хэтгэл

Байгууллага: Эрүүл мэндийн яам

№	Тайлбар	Эрсдэлийн түвшин	Удирдах	Түүнээс эмэгтэй албан хаагч	Гүйцэтгэх	Түүнээс эмэгтэй албан хаагч	Туслах	Түүнээс эмэгтэй албан хаагч	Албан тушаалын нийт тоо	Түүнээс нийт эмэгтэй албан хаагч	Эрсдэлийн үнэлгээ хамарсан албан хаагчийн хувь
1	Ажилтнаа байгаа нийт албан хаагч	78									
2	Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан албан хаагч	53	9	5	44	38	0	0	53	43	100.0
3	А.Төрийн албан хаагч өөрийн чиг үүргийн хүрээнд ажилладаг тушаалын бүй асуудал, бэршээлийг тодорхойлох	1-5	5	1	26	23	0	0	31	24	58.5
		6-10	3	3	17	16	0	0	20	17	37.7
		11-15	1	1	1	0	0	0	2	1	3.8
		16-20	0	0	0	0	0	0	0	0	0.0
	А.Нийт		9	5	44	37	0	0	53	42	
4	Б.Байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулал, сөйлын түвшин тохолдох бүй бэршээлийг тодорхойлох	1-5	2	0	19	16	0	0	21	16	39.6
		6-10	5	3	18	16	0	0	23	19	43.4
		11-15	1	1	5	3	0	0	6	4	11.3
		16-20	1	1	2	2	0	0	3	3	5.7
	Б.Нийт		9	5	44	37	0	0	53	42	

Дүгнэлт, нэмэх зүйл

Үнэлгээний асуултыг бөглөхөд үүссэн бэрхшээл /дурдах/ : Асуултыг бөглөхөд ойлгомжгүй байсан.

Үнэлгээний нэгтгэл дүгнэлт гаргасан ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргаС.Энхжин

А

	удирдах	гүйцэтгэх	туслах	нийт
1-5	5	26	0	31
6-10	3	17	0	20
11-15	1	1	0	2
16-20	0	0	0	0

Б

	удирдах	гүйцэтгэх	туслах	нийт
1-5	2	19	0	21
6-10	5	18	0	23
11-15	1	5	0	6
16-20	1	2	0	3

Ёс зүйн хорооноос “Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчил: Иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа” болон “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ”-ний үр дүнг танилцуулах, хэлэлцэх цахим уулзалтыг 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүд цахимаар идэвхтэй оролцсон.

Дөрөв. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад хамрагдах

Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах чиглэлээр 2025 онд нийт 17 гишүүн (давхардсан тоогоор) цахимаар болон танхимаар 6 удаагийн сургалтад хамрагдсан. Тухайлбал,

- Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах” сэдэвт цахим сургалтад Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 5 гишүүн;
- Удирдлагын академиас 2025 оны 03 дугаар сарын 11-12-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах” сэдэвт сургалтад Ёс зүйн дэд хорооны 3 гишүүн;
- Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 2025 оны 05 дугаар 21-23, 27-ны өдөр Ёс зүйн дэд хорооны 3 гишүүн;
- Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 28-29-ний өдөр зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” нийслэлийн зөвлөгөөнд 3 гишүүн;
- Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2025 оны 08 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан “Бэлгийн ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ” уулзалт, хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2 гишүүн;
- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын манлайлал, менежментийг сайжруулах, сахилга, хариуцлага, соёл, ёс зүйн хэм хэмжээг сахих чиглэлээр тулгамдсан асуудлыг хэлэлцэх, санал солилцох зорилгоор “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлага” үндэсний хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, нийт 150 гаруй хүмүүс оролцсон. Энэхүү

хэлэлцүүлэгт ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга болон нарийн бичгийн дарга оролцсон.

Тав. Бусад

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/66 дугаар тушаалаар Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх урамшуулал улиралд нэг удаа, нарийн бичгийн даргад сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50%-тай тэнцэх урамшуулал олгохоор шийдвэрлэн олгож байна. 2025 оны эхний 11 сарын байдлаар нийт 16.5 сая төгрөгийн урамшууллыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгосон байна. 2025 оны IV улирлын урамшуулал олгоогүй байна.

Мөн Ёс зүйн дэд хороодын гишүүд, яамны төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулахад байгууллагаас 1,080,000 төгрөг зарцуулж, дэмжлэг үзүүлсэн.

Тайлан хянасан:
Эрүүл мэндийн яамны дэргэдэх
Ёс зүйн дэд хорооны дарга С.Жаргалсайхан

Тайлан боловсруулсан:
Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн
дэд хорооны нарийн бичгийн дарга С.Энхжин

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЁС ЗҮЙН
ДЭД ХОРООНЫ ДАРГА Б.БАТБАЯР

1118270972 9087443

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО: Эрүүл мэндийн яамны албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах албан хаагч	Хамтрах нэгж
1	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах (удирдах, гүйцэтгэх албан хаагч тусд нь)	Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо	2025 оны II, IV улирал	Б.Пүрэвжав Б.Түвшинбаяр М.Хулан	ТЗУГ, Удирдлагын академи
2		Шинээр ажилд орсон албан хаагчдад чиглүүлэх сургалт зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо	Тухайн үед	Б.Оролзодмаа С.Энхжин	ТЗУГ
3		Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд сургалт зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо	2025 оны III улирал	Б.Түвшинбаяр Бусад гишүүд	ТЗУГ, Удирдлагын академи
4		Яамны аппаратын албан хаагчдын дунд өдөрлөг зохион байгуулах	Удирдамж, оролцогчдын тоо	2025 оны III улирал	Д.Ганзориг Бусад гишүүд	ТЗУГ

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах албан хаагч	Хамтрах нэгж
5		Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дунд “Ёс зүйг эрхэмлэгч хамт олон” сэдэвт аян зохион байгуулах	Удирдамж, тайлан	2025 оны II улирал	М.Хулан Д.Ганзориг Б.Оролзодмаа	-
6		“Өглөөний цайг хамтдаа” арга хэмжээг зохион байгуулах	Удирдамж, тайлан	2025 оны III улирал	Б.Батбаяр Б.Оролзодмаа М.Хулан Г.Түвшинбаяр	-
7		Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах	Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо	Тухай бүр, жилдээ	Бүх гишүүд	ТЗУГ
8		Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд ёс зүйн зөрчлийн хэлбэрүүдийг дурдаж оруулах, ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд хийгдэх зохицуулалт, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх тухай бүлэг нэмэлтээр оруулах	Оруулсан заалтын тоо	2025 оны I-II улирал	Бүх гишүүд	ТЗУГ
9	Ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах	Ёс зүйн дэд хороонд ирсэн гомдол, мэдээллийг хянан шалгах	Хянан шалгасан гомдол, мэдээллийн тоо	Тухай бүр, жилдээ	Бүх гишүүд, хуваарийн дагуу	-
10		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх дүгнэлтийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх, гарсан шийдвэрийн талаар мэдээлэл авах	Хүргүүлсэн дүгнэлтийн тоо	Тухай бүр, жилдээ	Бүх гишүүд, хуваарийн дагуу	-
11	Тайлан мэдээ	Ёс зүйн дэд хорооны хуралдааныг зохион байгуулах	Хуралдааны тоо	Жилдээ	С.Энхжин	-

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах албан хаагч	Хамтрах нэгж
12		Ёс зүйн дэд хорооны тайлан, мэдээг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Тайлан	Жилдээ	С.Энхжин	-
13		Ёс зүйн дэд хорооноос гарсан шийдвэрийг “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системд бүртгэж, нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийх	Цахим системд оруулсан шийдвэрийн тоо	Жилдээ, тухай бүр	С.Энхжин	-
14		Байгууллагын цахим хуудсанд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах	Цахим системд оруулсан шийдвэрийн тоо	Жилдээ, тухай бүр	С.Энхжин	-
15		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлан, шийдвэр, албан бичиг, гомдол, мэдээллийг шалгах явцад цугларсан холбогдох материалуудыг архивт хүлээлгэн өгөх	Архивт хүлээлгэн өгсөн материалын тоо	2025 оны I улирал	Б.Оролзодмаа	-

Төлөвлөгөө боловсруулсан:

Дэд хорооны нарийн бичгийн дарга С.Энхжин